



2019.10.31-ны одор Нийслэлийн Оргоо амаржих газар Эх барих, нярай, эмэгтэйчүүд, амбулаторийн тусламж, үйлчилгээгээр ISO 9001:2015 Чанарын менежментийн тогтолцоо гэрчилгээг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Стандарт хэмжилзүйн газар Ахлах мэргэжилтэн, Ахлах аудитор Д.Чимгээ гардуулан оглоо.

Эргэн санахад:2018.02.06-ны одор Нийслэлийн Ууган байгууллага болох Нийслэлийн Оргоо амаржих газар “AMU Consulting” ХХК-тай хамтран “Чанарын менежментийн тогтолцоо-шаардлага ISO 9001:2015 стандартыг нэвтрүүлэх ондор зорилт тавьж хамтын гэрээнд гарын үсэг зурж эхлүүлж байсан юм.

"ХАН ГОЛОМТ ГРУПП"-ийн “ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТОГОЛДОРШИЛ” ISO 9001:2015 стандартыг нэвтрүүлэх хотолборийн хүрээнд үйл ажиллагаандаа байнгын сайжруулалт хийх, чанарын бодлого, зорилтоо тодорхойлж 43 удаагийн цогц сургалтаар давхардсан тоогоор 3200 гаруй эмч, ажилчдыг сургаж, 49 журам, баримт бичгийн боловсруулалт, эмнэлгийн гадна, дотно тохижилтыг хийж эмч, эмнэлгийн ажилчид болон

вилчлүүлэгчдийн тав тухтай орчныг хангасан байгууллага болох ажлыг шат дараалалтайгаар хийж ажилласан байна.

Олон улсын ISO 9001:2015 Чанарын менежментийн стандартыг вил ажиллагаанд нэвтрүүлснээр амаржих газрын эмчилгээ, вилчилгээ, вил ажиллагаа ил тод, чирэгдэлгүй илүү хяналттай, эмх цэгцтэй, түргэн шуурхай, баталгаа нотолгоотой болж, хэрэглэгч, вилчүүлэгчийн сэтгэл ханамж дээшилхээс гадна гадаад харилцаа, дэвшилтэт технологийг нэвтрүүлж дэлхийн жишигт хүрсэн эмнэлэг болох эхний алхамаа ийнхүү тавьж байна.

Оргоо амаржих газрын эмч, эмнэлгийн ажилчид та бүхэндээ баяр хүргэе



